БАТЛАВ:
ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ж.ТАМИР

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР: **ТӨРИЙН ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨ ЦОГЦОЛБОРЫН ШИЛЭН ГАЛЕРЕЙН ТААЗ, ДЭЭВРИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР [VI.2.1.1]**
2	Байршил	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Төрийн ордон
3	Зориулалт, хүчин чадал	Төрийн Ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборын шилэн галерейн тааз, дээврийн хэсэгчилсэн засвар
4	Нууцлал, аюулгүй байдал	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд
5	Хөрөнгө оруулалт	Улсын төсвийн хөрөнгө оруулалт.
6	Барилгын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд	1. Ажлын талбай, түүний байршил, нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан байх зайлшгүй шаардлагатай. 2. Ажлыг гүйцэтгэх нарийвчилсан графикийг гаргаж батлуулах. 3. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. 4. Өдөр бүр ажил гүйцэтгэж дуусаны дараа засварын ажилд ашиглагдсан материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эмх цэгцтэй, хаалт, хамгаалалт хийж хураан байрлуулах, ажлын талбайг цэвэрлэнэ. Ажлын явцад гарсан хог хаягдлыг хотын зэрэглэлтэй төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дуусаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө. 5. Засварын ажил нь +14.00-с +23.80 метр хүртэлх төвшинд ажил гүйцэтгэх тул бараа материалыг өндөрт зөөх, буулгах техник, тоног төхөөрөмжийн шийдэл /подъём, кран гэх мэт/, засварын ажлын зохион байгуулалтын шийдлийг ажлын талбайтай танилцан гаргаж ирүүлнэ. Ажлын талбай нь онцгой бүс гэдгийг анхаарна уу. 6. Монгол улсын болон олон улсын стандартын шаардлага хангасан, гарал үүслийн бичиг болон тохирлын гэрчилгээтэй материал, эдлэлийг ашиглана. 7. Хэрэглэгдэх багаж хэрэгсэл, механизм, тоног төхөөрөмж нь техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй байдлыг хангасан байна.
7	Техникийн тодорхойлолт, тоо хэмжээтэй холбогдох шаардлагууд	1. Ажлын тоо хэмжээг сонгон шалгаруулалтад оролцогчийн удирдамж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолттой холбож ойлгоно. 2. Үнэлсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэ өртгийн ажлын тоог заасан заагаагүй, аль ч нөхцөлд тодорхойлсон байна. Гүйцэтгэгчийн бөглөөгүй орхисон үнэ өртгийг ажлын хэмжээнд тусгасан бусад ажлуудад шингээсэн гэж ойлгоно. 3. Гэрээний нөхцөлийн дагуу шаардагдах бүх зардлыг ажлын тоо хэмжээнд тусгасан ажлуудад шингээсэн гэж үзэн ямар

		нэгэн ажил тодорхойлоогүй үлдээсэн тохиолдолд түүний үнэ өртөг нь холбогдох ажлын үнэ өртөгт шингэсэн гэж үзнэ.
8	Захиалагчийн хяналтын ажил	1. Дээврийн засварын ажлыг гүйцэтгэж эхлэх үеэс эхлэн ажлыг хийж дуусгах хүртэлх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина. 2. Материалын чанарт хяналт тавина. 3. Ажлын явцад гарах зураг төсөвтэй холбоотой асуудлыг холбогдох хүмүүстэй хамтарч шийдвэрлүүлж хяналтын ажил хийнэ. 4. Магадалшгүй ажлын зардалд зориулсан мөнгөн дүнг төслийн гүйцэтгэгчийн шийдвэрийн дагуу захиалагч, гүйцэтгэгч, ашиглагчийн төлөөлөгчид оролцсон комисс акт тогтоон төсөв тооцоо хийж баталгаажуулж санхүүжих болно.
9	Гүйцэтгэгч байгууллага	- Ажлыг Барилгын тухай хууль, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандарт, норм норматив ын баримт бичгийн дагуу нийцүүлэн гүйцэтгэнэ. Барилга, угсралт, засварын ажлын технологийг мөрдөнө. - Захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардлыг төсөвт тусгаж өгнө. - Талбайд засварын ажлын журналыг байнга бэлэн байлгаж, холбогдох хяналтын инженерүүдийн өгсөн шаардлага, дүгнэлтийг журналд бичиж хөтлөн, биелүүлэн захиалагчаар баталгаажуулна. - Одоо байгаа цахилгаан, холбоо, сүлжээний утас, камер, гэрэл гэрэлтүүлэг, агааржуулалт, сантехникийн хоолой, барилгын үндсэн хийц, бүтээц, өнгөлгөө, шилэн галерей, шилэн купол, шилэн фонар, нүүрний шилэн хана, шилэн зураг, хөшөө, баримал, чулуун хийцүүд **/дахин давтагдашгүй урлагийн үнэт бүтээл/** тул **гэмтээж, эвдэхгүй,бохирдуулахгүй байх, хаалт хамгаалалт хийх** арга хэмжээ авч ажиллахыг **онцгой анхаарна уу!!!** Хэрэв эвдрэл гэмтэл учруулсан тохиолдолд гүйцэтгэгч өөрийн зардлаар бүрэн засварлаж захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө. - Засварын ажлын явцад барилгын хийц бүтээц, ИШС, шийдэлтэй холбоотой гарах асуудлыг газар дээр нь захиалагч болон бусад холбогдох инженер техникийн ажилчидтай хамтарч шийдэл гаргаж хэрэгжүүлнэ. - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа үүнээс гарах хор хохирлыг бүрэн хариуцна. Байгалийн гэнэтийн үзэгдэл, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана. - Ажил гүйцэтгэх явцад Төрийн ордон, ТЕХӨЦ-т ажиллагсдын ажиллах тав тухыг алдагдуулахгүйгээр, зочин төлөөлөгч болон ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр, хурал зөвлөгөөнийг тасалдуулахгүйгээр /дуу чимээ гаргахгүй, ойр орчныг бохирдуулахгүй байх, хаалт хамгаалалт хийх, ажлын бус цагаар ажиллах г.м/ талбайг зохион байгуулж захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр ажил гүйцэтгэх хугацааны санал боловсруулж мөрдөж ажиллана. Жич: Өндөр хэмжээний зочин төлөөлөгчийн

		айлчлал, төрийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээтэй үед ажлыг түр зогсоох шаардлагатайг анхаарна уу. - Барилгын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтад өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийж, ажил гүйцэтгэх графикт тусгах шаардлагатай. - Ажил гүйцэтгэхдээ Төрийн ордны тухай хууль болон дотоод журам бусад холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөнө.Төрийн ордны өрөө тасалгааны байрлал, зохион байгуулалт болон ажил гүйцэтгэх явцад олж авсан бусад мэдээлэл, төрийн нууцлалыг алдагдуулахгүй байх баталгааг хангаж ажиллана.
10	Материалд тавигдах шаардлага	1. Ашиглах материал нь энэ тодорхойлолтод заагдсан тоо хэмжээ, тавигдах шаардлага, чанарыг хангаж байх шаардлагатай. 2. Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай, олон улсын стандартад нийцсэн сертификат, тохирлын гэрчилгээтэй, хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байна. 3. Мөн эдгээр материал эдлэлийн үнэ нь нийтэд зарлагдсан үнээс ихгүй байна. 4. Будаг нь гадаргууд тогтоц сайтай, барьцалдах, ус тусгаарлах өндөр чадвартай, цаг уурын (±) 40 хэм, цохилт, зэврэлт, үрэлт тэсвэртэй, батлагдсан өнгө дагуух, өнгө хувиралгүй, /Тиккурила ТЕМАКОУТ GPL-S MIO/ будагтай дүйцэхүйц ба түүнээс дээш чанарын шаардлага хангасан байна. 5. Хавтан нь өнгө, чанарын хувьд 20-оос доошгүй жилийн үйлдвэрийн баталгаатай, зэвэрдэггүй, хөнгөн, цаг уурын нөлөөлөлд хэв гажилтад орохгүй, бэхэлгээний хувьд салхины ачаалалд тэсвэртэй, 40^0С хэмд тохирсон. Өнгийг захиалагчтай зөвшилцөх. 6. Эмульс нь гадна зориулалтын MNS 5252:2003 шаардлагыг хангасан. Өнгөний хувиралгүй байна. Өнгийг захиалагчтай зөвшилцөх. /NOROO/ солонгос эмульстэй дүйцэхүйц ба түүнээс дээш чанарын шаардлага хангасан байна. 7. Гөлмөн төмөр нь MNS 3219:82 стандартыг хангасан. б=0,9мм доошгүй зузаантай байна. 8. Чигжээс нь цаг уурын (±) 40^0С хэмд тэсвэртэй, барьцалдах чадвар өндөртэй, гадаргуугийн дагуу өнгөтэй, MNS ISO 11600:2002 стандартыг хангасан байна.
11	Аюулгүй ажиллагааны шаардлага	1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, галын аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн, ХАБЭА-н ажилтныг тогтмол ажиллуулан ажилчдадаа заавар, анхааруулгыг өгч, ажлын талбайд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, эрсдэл өндөртэй цэгүүдэд хаалт хамгаалалт, хашаа хийх, өндөрт ажиллах тохиолдолд өндрийн хамгаалах хэрэгсэл, тоноглолыг бүрэн хангуулан ажиллана. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна. 2. Ажлын байрны аюултай хэсгийг тогтоосон хэмжээний анхааруулах тэмдгээр тэмдэглэх 3. Ажлын байрнаас орж гарах бүх гарцад элдэв саадгүй

		байлгаж цэвэрлэж байх 4. Бүтээцийн эдлэл материал, тоног төхөөрөмжийг стандарт болон техникийн шаардлагын дагуу хурааж хадгалах. 5. Барилгын машин механизмыг зохих стандартын шаардлагын дагуу ашиглах 6. Ажлын байранд цахилгааны аюулгүй байдлыг сахих нөхцөлийг бүрдүүлэх

Техникийн тодорхойлолтод заагдсан шаардлага биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч эрхийнхээ дагуу ажлыг зогсоож зөрчлийг арилгуулсны үндсэн дээр засварын ажлыг үргэлжлүүлнэ.

Одоо байгаа байдлын зураг хавсаргав.

Том куполийн хүрээ /+23.83/ түвшин





/+17.00/ түвшиний хүрээ





/+14.30/ түвшиний хүрээ

Дээд талаас

Доод талаас



ХЯНАСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА Т.БОЛДБААТАР

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ГАЛЕРЕЙН ТААЗ, ХАШЛАГА ХАНЫН ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Шарласан тааз, карниз, хүрээний гадаргууг хусаж цэвэрлэх	м2	900
2	Барзгар шавардлагын засвар хийх	м2	300
3	Мөн гадаргууд замаск тэгшилгээ хийх	м2	900
4	Грунт ус чийг тусгаарлагч , барьцалдуулагчийг түрхэх ([k1=0.8])	м2	3120
5	Галерейн тааз, карниз, хүрээ, хашлага хана, цонхны амалгаа бусад хийцийг хусаж цэвэрлэн эмульсдэх	м2	3120
6	Гадна ханын заслалын ажилд 16 м хүртэл өндөр төмөр шат угсрах ба задлах ([k1=0.8])	м2	1720
7	Цонхны амалгааны шаврын засвар хар замаскаар хийх ([k1=0.8])	м2	6.5
8	Цонхны ус зайлуулах цайрдсан төмөр солих	м2	6.3

ДЭЭВРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Том куполын хүрээний цайрдсан төмөр буулгах	м2	115.5
2	Мөн куполын хүрээг цайрдсан төмрөөр бүрж хадах	м2	115.5
3	Гадна зориулалттай цементэн хавтангаар налуулга гарган тэгшилгээ хийх	м2	115.5
4	Дээврийн 1 үе тусгаарлагч түрхлэг хийх	м2	115.5
5	Купол, төмрийн уулзварыг шаваасаар битүүлэх ([k1=0.7])	м	45
6	17.00, 14.30 түвшиний карнизийн хиймэл чулуун хавтан буулгах	м2	96.04
7	Мөн карнизийг металжсан хавтанцараар өнгөлөх ([k1=0.8])	м2	137.2
8	17.00, 14.30 түвшиний карнизийн цайрдсан төмөр доогуур ус зайлуулах хормойвч цайрдсан төмөр угсрах ([k1=0.8])	м2	82.32
9	Төмөр гадаргуугийн зэвийг сойзоор цэвэрлэх	м2	1031.6
10	Хуучин будагтай төмөр дээврийг tlkkurlla будгаар будах	м2	1031.6
11	Том куполын доорх металжсан хавтанг угааж цэвэрлэх	м2	600
12	Куполын хүрээнд бэхэлсэн гэрэлтүүлэгч гэмтээхгүйгээр буулгах	100ш	0.39
13	Мөн гэрэлтүүлэгчийг буцааж байрлуулах	ш	39